

**“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь:  
Асуудал ба шийдэл” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага  
хуралд зориулав**

# **ИЛТГЭЛ**

**Сэдэв: “Автомашины дугаар олголт ба авилгал”**

Илтгэгч: МУИС-Хууль зүйн сургууль, Японы эрх зүй 5-р курс,  
Ганбатын **Батаа**

2011 он

**Гарчиг**

**Нэг. Удиртгал**

1.1.Автомашины дугаар олголт ба авилгалтай холбоотой эрх зүйн асуудал

1.2.Судалгааны ач холбогдол

1.3.Судалгааны зорилго

1.4.Судалгааны арга

**Хоёр. Автомашины дугаар олголт ба авилгал - Судалгаа**

2.1.Ерөнхий нөхцөл байдал

2.2. Хууль тогтоомжинд хийсэн судалгаа

2.3. Авилгалын тогтолцоо

2.4. Асуудал бий болох шалтгаан

**Гурав. Асуудлыг шийдвэрлэх арга замууд**

3.1.Авилгалтай тэмцэх арга зам

3.2.Товч дүгнэлт

**Дөрөв. Бусад улс оронтой харьцуулалт – Харьцуулсан судалгаа**

4.1. Япон улсын хувьд

4.2.Товч дүгнэлт

**Тав. Илтгэгчийн санал**

**Зургаа. Ашигласан материал**

*Авилгалыг хараа, хяналтгүй аливаа хязгаарлалтгүй зөнгөөр орхихыг нь зүйрлэвэл хорт хавдар лугаа адил маш хурдан даамжрах аюултай.*

## Нэг. Удиртгал

Монголд хөрөнгө мөнгөтэй иргэд нь автомашиндаа азын гэх ижил оронтой тоо сонгох явдал нь моод болоод байгаа бөгөөд үүнийг дагаад тус дугааруудын үнэ эрс нэмэгдэж байна. Тухайлбал интернэтийн сайтаас үзвэл “Өдгөө дөрвөн ижил оронтой дугаарын үнэ 2000 ам.долларт хүрч, үүний хэрээр шинэ цагийн баячууд өөрсдийнхөө хэр хэмжээг тодорхойлох болсон гэхэд нэг их хилсдэхгүй болов уу”<sup>1</sup> гэх зэргээр нийтлэл тавигдсан байна. Үүнийг дагаад албан тушаалын байдлаа ашиглан эрх мэдэлтнүүд дугаарыг наймаалцах явдал газар авч байна. Үүний нэг жишээ нь Дархан-Уул аймгийн Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албаны салбарын тоо бүртгэлийн мэргэжилтнээр ажиллаж байсан ажилтан нь улсын дугаар шаглахаас гадна бусдыг залилан мэхэлсэн гэмт хэрэгт холбогдож, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэст шалгуулж байна. Мөрдөн байцаалтын явцад нэр бүхий 10-аад хүнд азын дугаар худалдсан нь тогтоогдсон байна<sup>2</sup>. Тиймээс энэхүү авилгал, хээл хахууль гэх хууль бус үйл ажиллагааг газар авахтай тэмцэх, зайлшгүй арга хэмжээ авах шаардлагтай байна. Авлига гэдгийг Авилгалын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд, албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно.\Авлигын эсрэг хууль 3.1.1\

Энэхүү асуудалтай холбоотойгоор нийгэмд автомашины дугаар олголтыг буцааж Замын цагдаагийн газар олгох, улсын дугаарыг 3 оронтой цифрт шилжүүлэх гэх мэт арга хэмжээний талаар яригдаж байна. Гэхдээ эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлээ ч авилгал, хээл хахууль төдийлөн буурахгүй юм. Учир нь хуулиар хориглох тусам түүний үнэ цэнийг улам бүр нэмэгдүүлж байдаг бөгөөд өөрийн дуртай дугаараар гангарах, нэр хүндийг эрхэмлэх хүмүүсийн эрэлт нийгмийн хандлагаар буурахгүй, харин ч эсрэгээрээ улам бүр өсөж магадгүй. Үүнийг дагаад авилгал, хээл хахууль, мөн далд бизнесийг цэцэглэн хөгжүүлж магадгүй юм. Тиймээс энэхүү асуудлыг бүтцийн хүрээнд шийдвэрлэх

<sup>1</sup> <http://www.mongolnews.mn/p/23706>

<sup>2</sup> <http://www.mongolnews.mn/p/24777>

шаардлагтай бөгөөд үүнтэй холбоотойгоор авилгалын бүтцийг судалж түүнд тохирсон арга хэмжээ авах шаардлагтай юм.

#### 1.1. Автомашины дугаар олголт ба авилгалтай холбоотой эрх зүйн асуудал

Автомашины дугаар олголттой холбоотой авилгалын бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна. Энэ нь хамгийн эхэнд автомашины шинэ дугаарууд нь Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас Зам тээврийн газрын албан хаагчид очно. Ингэснээр албан хаагчид шинэ дугаар задлах үед зарим нь иргэнийхээ хувиар азын дугаар сонгож авах, зарим нь албан тушаалынхаа хувиар шууд сонгож авна. Үүний дараа бизнесийн бүлэглэл, хувь хүнд өндөр үнээр худалдаж, эдгээр авсан хүмүүс нь цааш улам өндөр үнээр худалдаж байна. Эдгээр харилцаанд авилгалын асуудал үүсэх магадлалтай харилцаа нь албан хаагчаас бизнесийн бүлэг, хувь хүнд азын дугаарыг шилжүүлэх үед юм. Энэхүү ээдрээтэй авилгалын сүлжээг мөрдөн байцаагч нар илрүүлэхэд үндсэндээ хүндрэлтэй юм. Учир нь тухайн төрийн албан хаагчид иргэнийхээ хувиар азын дугаарыг авч бусдад шилжүүлж байгаа тохиолдолд Эрүүгийн хуулиар хариуцлага тооцоход хүндрэлтэй юм. Түүнчлэн төрийн албан хаагчийн хувиар шууд өөрөө иргэдэд шилжүүлсэн тохиолдолд ч авилгалын асуудал илрэхэд хүндрэлтэй юм. Учир нь олон этгээдээр дамжилгүй шууд өгч байх бөгөөд өгсөн авсан этгээдүүдийн хооронд нууцлагдах юм. Тиймээс эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар энэхүү судалгаанд авч үзнэ.

#### 1.2. Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгааг хийснээр автомашины дугаар олголттой холбоотой авилгалын асуудлаар хийсэн нарийвчилсан анхны судалгаа болох бөгөөд дугаар олголттой холбоотой авилгалын асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болох юм.

#### 1.3. Судалгааны зорилго

Автомашины дугаарыг дагсан авилгал хээл хахуультай холбоотой асуудал байна. Тиймээс энэхүү асуудал үүсч байгаа шалтгааныг тодруулж, асуудлыг шийдвэрлэхийн тулд бусад улстай харьцуулсан судалгаа хийж асуудлыг шийдэх арга замыг тодруулах ба үүнтэй холбоотой Авилгалтай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах талаар санал, дүгнэлт гаргах нь гол зорилго юм.

#### 1.4. Судалгааны арга

Судалгааны арга нь хууль зүйн шинжлэх ухааны онолтой салшгүй холбоотой бөгөөд төр, эрх зүйн мөн чанар, зүй тогтол, онцлог, чиг үүргийг

танин мэдэхэд үйлчлэн тусалдаг<sup>3</sup> гэсэн байна. Тиймээс автомашины дугаар олголттой холбогдсон эрх зүйн бичиг баримтанд эмпирик судалгаа хийж, түүний мөн чанар, онцлог, чиг үүргийг танин мэдэхийн тулд харьцуулалтын арга, дестректив арга зэргийг хэрэглэсэн болно.

### **Хоёр. Автомашины дугаар олголт ба авилгал - Судалгаа**

#### **2.1. Ерөнхий нөхцөл байдал**

Үндэсний статистикийн газрын 2011 оны 1-р сарын мэдээнээс үзвэл нийтийн тээврийн хэрэгсэл 232 ширхэг, суудлын автомашин 2 558 ширхэг, ачааны автомашин 1 723 ширхэг гаднаас импортоор орж ирсэн байна. Энэхүү тоо баримтыг 2010 оны 1-р сартай харьцуулж үзвэл 2010 оны 1-р сард нийт 1137 ширхэг тээврийн хэрэгсэл импортоор орж ирсэн бол 2011 оны 1-р сард нийт 4 513 ширхэг тээврийн хэрэгсэл буюу 4 дахин өссөн байна. Эдгээр импортоор орж ирж байгаа тээврийн хэрэгслүүд болон хараахан бүртгүүлж амжаагүй байгаа тээврийн хэрэгслүүд нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Авто тээврийн газарт бүртгүүлж, дугаар авах шаардлагтай юм. Авто тээврийн тухай хууль 17.4, 17<sup>1</sup>.4\ Энэхүү Авто тээврийн газарт албан бус баримтаар<sup>4</sup> өдөрт дунджаар 350-400 ширхэг автомашин бүртгүүлж, дугаар авч байна.

#### **2.2. Хууль тогтоомжинд хийсэн судалгаа**

Автомашины тоо бүртгэл нь анх 1925 оны 1-р сарын 23-ны өдрийн Ардын засгийн газрын 3-р хурлаас авто тээврийн ашиглалтыг сайжруулах үүднээс “Уурын тэргийн товчлон эрхлэх газар” байгуулсан байна. Үүний дараа 1936 оны 6-р сарын 13-ны өдрийн Ардын сайд нарын зөвлөлийн 30-р тогтоолоор ууран тэрэг ашиглах, тоо бүртгэл хөтлөх, хяналт тавих асуудлыг эрхлэх ажлыг Цагдаагийн байгууллагад хариуцуулсан байсан бөгөөд 2008 онд Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт орж тээврийн хэрэгслийн тоо бүртгэл дугаар олгох ажлыг Замын цагдаагийн газраас Авто тээврийн газарт шилжүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Тус нэмэлт өөрчлөлт нь Авто тээврийн тухай хуулийн 6.1.8-д хуульчлагдсан байна.

Авто тээврийн тухай хуулийн 17<sup>2</sup>.2-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, дугаар олгох журмыг авто тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсэн бөгөөд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 1-р сарын 20-ны өдрийн 19-р дугаар тушаалаар “Авто тээврийн газрын

<sup>3</sup> Сэнгэдорж.Т “Хууль зүйн шинжлэх ухаан” 2006 он, 73-р тал

<sup>4</sup> Авто тээврийн бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Лхавгасүрэнгийн ярианаас авав.

бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журмыг баталсан байна. Тус журамын 3.1-д автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэж, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар олгох, 6-д Автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг аймаг, нийслэлийн бүртгэлийн байгууллагаар дамжуулан олгоно гэж зохицуулсан боловч шинэ дугаарыг хэрхэн задлах, азын дугаарыг хэрхэн яаж олгох, ямар дугаарыг азын дугаарт тооцох зэрэг асуудлыг тодорхойгүй орхисон байна.

### 2.3. Авилгалын тогтолцоо

Автомашины дугаар олголттой холбоотой авилгалын сүлжээ нь ээдрээтэй болох талаар дээр өгүүлсэн. Энэ нь нэгдүгээрт төрийн албан хаагчид иргэнийхээ хувиар азын дугаарыг авч бусдад шилжүүлж байгаа тохиолдолд мөрдөн байцаагчид албан тушаалын эсрэг гэмт хэргээр шалгаж, шүүх нь Эрүүгийн хуулиар хариуцлага тооцох боломжгүй болж байна. Учир нь төрийн албан хаагч иргэний хувиар өөртөө авсан тохиолдолд “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журам зөрчихгүй бөгөөд эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзэхгүй юм. Түүнчлэн бусдад шилжүүлээгүй учир авилгал хээл, хахууль өгсөн авсан болохгүй юм. Өөрөөр хэлбэл албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь “гэмт халдлагад өртсөн, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан бусдын эрх ашиг, сонирхол байдаг”<sup>5</sup> бөгөөд үүнд чиглэгдсэн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйгээр чиглэсэн байх ёстой байна.

Хоёрдугаарт албан хаагч эрх мэдлээ ашиглан өөрөө иргэнд шууд шилжүүлсэн тохиолдолд авилгал авсан гэдгээр Эрүүгийн хариуцлага тооцох үндэслэлтэй боловч тус авилгалын асуудал өгсөн, авсан этгээдүүдийн хооронд нууцлагдаж илрэхэд хүндрэлтэй юм. Өөрөөр хэлбэл мөрдөн байцаагчийн хувьд “ашиг олох сонирхолтой этгээд, эрх мэдлээ уг этгээдэд борлуулж байгаа албан тушаалтнуудын ашиг сонирхлын нэгдэл байдаг учир тэдний эсрэг нотох баримт цуглуулж бэхжүүлэх нь их хүч шаардсан төвөгтэй байдаг”<sup>6</sup> гэсэн байна. Гэхдээ эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд авилгал, хээл хахууль өгч, авч байгаа хэсэгт анхаархаас илүүтэйгээр авилгал, хээл хахууль өгөх, авах боломж бүрдэж байгаа хэсэгт анхаарах нь чухал юм. Өөрөөр хэлбэл “авилгалтай тэмцэх ажиллагааг гарсны дараа таслан зогсоох гэдэг нь бүтэшгүй

<sup>5</sup> Бумнаажид.Ж, Мягмарцэрэн.Ш, “Авилгал, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал”,Авилгалтай тэмцэх газраас гаргасан,2011 он 10-р хуудас

<sup>6</sup> Дээрх номны 10-р хуудас

зүйл. Гэмт хэрэг хийсний дараа бус хийхээс өмнө урьдчилан сэргийлэх нь боломжийн арга”<sup>7</sup> гэсэн байна. Тиймээс автомашины дугаар Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас Зам тээврийн газрын албан хаагчид очиж байгаа тэр хэсэгт анхаарах ёстой юм.

#### 2.4. Асуудал бий болох шалтгаан

1. “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд шинэ дугаарыг хэрхэн задлах, азын дугаарыг хэрхэн яаж олгох, ямар дугаарыг азын дугаард тооцох зэрэг асуудлыг тодорхойгүй орхисон байна

2. Автомашины дугаартай холбоотой авилгал бий болох нөхцөл нь автомашины дугаар Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас Зам тээврийн газрын албан хаагчид очиж байгаа тэр хэсэгт үүсч байна.

### **Гурав. Асуудлыг шийдвэрлэх арга замууд**

#### 3.1.Авилгалтай тэмцэх арга зам

Дээрх авилгал бий болох үндсийг таслан зогсоохын тулд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас азын дугааруудыг шууд иргэдэд олгох боломжийг бүрдүүлэх ёстой байна. Ингэснээр хоёр дахь асуудал болох иргэний хувиар азын дугаар авч байгаа албан тушаалтан нь зайлшгүй албан тушаалын нэрээр авилгал, хээл хахууль авах учир Эрүүгийн хуульд заасан албан тушаалын эсрэг гэмт хэрэгт тооцох нөхцөл бүрдэх юм. Үүний тулд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам нь азын дугаарыг нийтэд зарлаж нээлттэй дуудлага худалдаа явуулах нь зүйтэй юм. Энэхүү дуудлага худалдаагаар олсон орлогийг нийгэмд ашигтай зүйлд зарцуулахаас гадна Зам тээврийн газрын ажилтны цалин нэмэхэд анхаарах ёстой юм. Учир нь “авилгал нь нөхцөл боломж, хүсэл шунал хоёр зэрэг байгаа үед бий болох”<sup>8</sup> бөгөөд цалингийн хэмжээ бага байгаа нөхцөлд авилгал авах хүсэл, хэрэгцээ зайлшгүй гарч ирэх юм. Тиймээс дуудлага худалдаагаар олсон орлогоор Автотээврийн газрын албан хаагчийн цалинг нэмснээр авилгалд өртөх магадлал багсах юм. Үүнтэй уялдаад “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд хэрхэн азын дугаарыг дуудлага худалдаагаар худалдах талаар дэлгэрэнгүй зохицуулах нь зүйтэй юм.

#### 3.2.Товч дүгнэлт

---

<sup>7</sup> Батбаатар.А “Цогцолбор арга хэмжээ хэрэгтэй” “Авилгал: Мөнхийн үзэгдэл биш”Зориг сан, МННХ(Соросын сан)-аас гаргасан, 2002 он, 37-р хуудас

<sup>8</sup> Жереми Поул “Авилгалын эсрэг эх сурвалж бичиг”, 2003 он, хуудас 17

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас азын дугаарыг дуудлага худалдаанд зарлаж, олсон орлогийг Зам тээврийн газрын ажилчидын цалинг нэмэх нь зүйтэй байна. Үүнтэй холбоотой “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд хэрхэн азын дугаарыг дуудлага худалдаагаар худалдах талаар дэлгэрэнгүй зохицуулах шаардлагтай юм.

### **Дөрөв. Бусад улс оронтой харьцуулалт – Харьцуулсан судалгаа**

#### **4.1. Япон улсын хувьд<sup>9</sup>**

Япон улсын автомашины дугаар нь хамгийн эхэнд харьяалж байгаа газрын нэр, дараа нь машины маркийг илэрхийлэх дугаар, түүнчлэн ямар зориулалтаар ашигладаг машин болох үсгэн тэмдэглэгээ зэрэг байдаг байна. Үүнтэй уялдаад Японд автомашины дугаарыг бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд автомашин жагсаалаас гарах хүртэл дугаар нь машинтайгаа хамт байдаг байна. Хэрэв тухайн машины унах хугацаа дуусч жагсаалаас гарсан тохиолдолд дугаарыг нь бүртгэж өөр машинд олгодог байна. Гэхдээ энэхүү тогтолцоог манай улсад авч ашигласнаар дугаар давхардуулан олгох, дугаарын үнэ буурах боломжтой боловч авилгал, хээл хахуулийн хувьд төдийлөн үр дүн гарахгүй байх магадлалтай юм. Учир нь иргэд азын дугаар авах эрэлт нь буурахгүй бөгөөд машины үнэ дээр дугаарын үнэ нэмэгдэж машины үнэ мөн нэмэгдэх нөхцөл болох юм. Ингэснээр азын дугаар авахтай холбоотой авилгал мөн буурахгүй гэж үзэх боломжтой юм.

Дээрх тэмдэглэгээний дараа 4 орон бүхий тоо байх бөгөөд 1999 оны 5-р сарын 14 өдөр дуртай дугаарыг нь иргэддээ олгох тогтолцоог хэрэгжүүлсний үр дүнд Японы иргэд өөрийн хүссэн дугаарыг авах боломжтой болсон байна. Гэхдээ азын дугаарыг иргэдэд жирийн дугаараас арай илүү тогтоосон мөнгөөр өгч байна. Ийнхүү олгохдоо олны анхаарал татах ---1, ---7, ---8, --88, -333, -555, -777, -888, 1111, 3333, 5555, 7777, 8888 гэсэн 13 дугаарыг шавга суглах аргаар иргэдэд олгож байна. Дашрамд дурдахад Японд 4, 9 гэсэн дугаар нь муу утгыг илэрхийлдэг учир Японы иргэд аль болох авахаас зайлсхийдэг байна. Энэхүү шавга суглах арга нь манайд хэрэгжүүлэх боломжтой байна. Гэхдээ энд анхаарах ёстой зүйл нь шавга суглахаас өмнө зарим азын дугаарыг авах, шавга сугласан нэрийдлээр азын дугаарыг бусдад шилжүүлэх магадлалтай юм.

---

<sup>9</sup>Дэлгэрэнгүй.<http://ja.wikipedia.org/wiki/%E6%97%A5%E6%9C%AC%E3%81%AE%E3%83%8A%E3%83%B3%E3%83%90%E3%83%BC%E3%83%97%E3%83%AC%E3%83%BC%E3%83%88>



Тиймээс дээр дурьдсанаар Автотээврийн газраар дамжилгүй, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас азын дугаарыг зарлаж, шавга суглах аргаар иргэдэд олгох нь зүйтэй байна. Ингэснээр иргэний хувиар азын дугаарыг түрүүлж авах боломжгүй болох ба Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн газрын албан хаагчид албаны нэрээр дугаар авбал албан тушаалын эсрэг гэмт хэргээр мөрдөн байцагч нар шалгаж хуульд зааснаар Эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болох юм.

#### 4.2.Товч дүгнэлт

1. Японд автомашины дугаарыг өөр автомашинд шилжүүлэх боломжгүй байна. Хэрэв энэхүү тогтолцоог манай улсад авч ашиглавал дугаар давхардуулан олгох, дугаарын үнэ буурах боломжтой ч авилгал, хээл хахуулийн хувьд төдийлөн үр дүн гарахгүй байх магадлалтай байна.

2. Японд олны анхаарал татах азын дугаарыг арай илүү төлбөр төлж, шавга суглах аргаар сонгож байна. Үүний манай улсад Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулах нь зүйтэй байна.

3. Японд азын дугаарыг нийтлэг байдлаар тогтоосон байна. Ингэж тогтоохдоо тооны билэгдэл, олны дунд байгаа үнэлэмжийг харгалзаж үзсэн байна. Үүнийг манай улсад хэрэгжүүлэх боломжтой бөгөөд “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд ямар дугаарыг азын дугаар гэж тооцох талаар дэлгэрэнгүй зохицуулах нь зүйтэй юм.

#### **Тав. Илтгэгчийн санал**

1. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас азын дугаарыг дуудлага худалдаанд зарлаж, олсон орлогийн нэг хэсгээр Зам тээврийн газрын ажилчидын цалин нэмэх нь зүйтэй байна. Үүнтэй холбоотой “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд хэрхэн азын дугаарыг дуудлага худалдаагаар худалдах талаар дэлгэрэнгүй зохицуулах нь зүйтэй юм.

2. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас олны анхаарал татах азын дугаарыг арай илүү төлбөр төлж, шавга суглах аргаар иргэдэд олгож болох байна.

3. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас азын дугаарыг нийтлэг байдлаар тогтоох шаардлагтай байна. Ингэж тогтоохдоо тооны билэгдэл, олны дунд байдаг үнэлэмжийг харгалзаж үзэх нь зүйтэй. Үүнтэй холбоотой “Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журамд ямар дугаарыг азын дугаар гэж тооцох талаар дэлгэрэнгүй зохицуулах юм.

## **Зургаа. Ашигласан материал**

### Хууль тогтоомж

- Авлигын эсрэг хууль, 2006 он
- Автотээврийн тухай хууль, 1999 он
- Автотээврийн газрын бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам, Зам тээвэр,барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 1-р сарын 20-ны өдрийн 19-р дугаар тушаал

### Ном

- Бумнаажид.Ж, Мягмарцэрэн.Ш, “Авилгал, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал”,Авилгалтай тэмцэх газраас гаргасан,2011 он
- Зориг сан, МННХ(Соросын сан)-аас гаргасан “Авилгал: Мөнхийн үзэгдэл биш”, 2002 он
- Жереми Поул “Авилгалын эсрэг эх сурвалж бичиг”, 2003 он
- Сэнгэдорж.Т, “Хууль зүйн шинжлэх ухаан”2006 он

### Ашигласан сайт

- <http://www.mongolnews.mn>
- <http://ja.wikipedia.org>